

Гүйцэтгэсэн: Ялгуун интернэшнл ХХК-ны захирал.....З.Нацагдорж

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ СӨГДӨХИЙН ШОХОЙН
ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-002425**

Хянасан: Дорноговь аймгийн Байгаль орчины газрын Уул уурхайн үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн:..... Ш.Амарбилэг

Боловсруулсан: Ялгуун интернэшнл ХХК-ны Байгаль орчны
мэргэжилтэн:.....Э.Пүрэвдорж

2024он

ГАРЧИГ

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1	Төслийн ерөнхий мэдээлэл байршил.....	3
1.2	Төслийн ашиглалтын технологи.....	4
1.3	Төслийн хүчин чадал.....	5
1.4	Шохойн чулууны олборлолт, баяжуулалт.....	6

ХОЁР.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОХОЙЛОЛТ

2.1	Болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт.....	7
2.2	Болзошгүй нөлөөллийн тоон үнэлгээний нэгтгэл.....	8
2.3	Төсөл хэрэгжилтийн үеийн байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл.....	9

ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	11
3.2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	15
3.3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	15
3.4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	16
3.5	Түүх,соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	18
3.6	Хог,хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	18
3.7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	19
3.8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр,түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт.....	20

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ.....21

ТАВ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....22-60


НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл байршил

Сөгдөхийн шохойн чулууны орд нь Дорноговь аймгийн төв Сайшандаас зүүн урагш 55км-т, Судалгааны талбай нь Улаанбаатар-Замын Үүдийн төв магистраль авто замаас баруун урагш 8 км шороон замаар холбогдсон. Зам харилцаа, дэд үтцийн хувьд сайн хөгжсөн орон нутагт хамаарагдах бөгөөд Улаанбаатар хотоос Замын үүд хүртэл асфальтан замтай.

- Талбайн хэмжээ: 31.5 га (МУ-002425 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай 29 га, үйлдвэрийн талбай 2.5 га)

➤ Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49-125



№	Уртраг	Өргөрөг
1	110° 29' 40.85''	44° 36'58.57''
2	110° 29' 15.86''	44° 36'58.57''
3	110° 29' 15.86''	44° 37'15.57''
4	110° 29' 40.85''	44° 37'15.57''



Зураг 1. Шохойн чулууны орд газар орчмын сансрын зураг

1.2 Төслийн ашиглалтын технологи

Ил уурхайн ашиглалтын технологи: Ордын тогтоц болон уул техникийн нөхцөлөөс нь хамааруулан уурхайд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем сонгосон ба үүнд шаардлагатай дараах механикжуулалтын бүтэц тохиромжтой

Доголын өндөр. Хүдрийн хаягдал бохирдлыг бага байлгах, уурхайн жилийн хүчин чадал, ажиллах тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт, хөрс болон шохойн чулууны физик механикийн шинж чанар зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн ажлын доголын өндрийг $H_d=5$ м байхаар тооцов. Доголын өндөр бага байснаар шохойн чулуу хөрсний чулуулгийн зааг орчимд үүсэх хаягдал болон бохирдлын хэмжээ багасах нөхцөл бүрдэнэ.

Ажлын бус доголын өндөр. Ажлын догол нь ажлын бус бүсэд шилжихэд ажлын хоёр доголыг нэгтгэн хурааж ажлын бус 10м-ийн өндөртэй догол үүсгэнэ.

Ажлын доголын хажуугийн өнцөг. Ажлын доголын хажуугийн өнцөг нь чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр $\alpha_d=50^0-60^0$ байна. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй ($f=7-8$ бол $\alpha_d=40^0-60^0$).

Ажлын талбайн өргөн. Уурхайн ажлын догол дээрх ажлын талбайн зөвшөөрөгдөх хамгийн бага өргөн нь автосамосвал гогцоо хэлбэрийн эргэлттэй хөдөлгөөний үед $W_{\min}=12$ м байна.

Фронтын урт. Доголын фронтын урт нь тухайн доголын ерөнхий хэмжээнээс (уртаас) хамаарна. Доод түвшингүүдийн доголуудад фронтын урт багасна. Урт нь ордын хувьд $40 \leq L_f \leq 100$ м байна.

Ил уурхайн ёроолын өргөн. Уурхайн ёроолын өргөн ажиллаж байгаа техникийн аюулгүй нөхцөлөөр тодорхойлогдоно. Уурхайн ёроолд автосамосвалнь гогцоо хэлбэрийн схемээр маневрлахба экскаваторнь ухаж ачих ачилт хийнэ. Иймд ил уурхайн ёроолын хамгийн бага өргөн (ажлын талбайн хамгийн бага өргөн) 18 м-ээс багагүй байна.

Ажлын талбайн хамгийн бага өргөн= $6.0*2+3.1+1.8+1.8=17.9 \approx 18$ м

Ажлын талбайн хамгийн бага өргөн

Автотээврийн хэрэгслийн дотоод эргэлтийн радиус, м	6
Автосамосвалын өргөн, м (25 тн даацтай)	3.1
Аюулгүйн зай, м	1.8
Ажлын талбайн хамгийн бага өргөн, м	17.9

1.3 Төслийн хүчин чадал

Тус төслөөр жилд 210000 тн шохойн чулуу олборлох хүчин чадалтай уурхайг түшиглэж жилийн хүчин чадал нь 50000 тн шохой боловсруулсан үйлдвэр байдаг боловч зах зээлээс хамаарч өдөрт гаргах бодит бүтээл 50 тн, сард гарах бодит бүтээл 1500 тн жилийн бүрэн хэмжээгээр хүчин чадал 18000 тн шохой боловсруулах горимоор одоогийн байдлаар ажиллаж байна.

Шохойн чулууг боловсруулах технологийн горимыг туршилтууд, шинжилгээний үр дүнг үндэслэн шохойн идэвх нь 1000 °C температурт шатаахад 81.87%, тунах хугацаа нь 5 минут, туналтын температур 58 °C байж “MNS-347-2002” стандартын шаардлага хангасан



600°C-ээс дээш температурт нүүрсхүчлийн кальци задарч эхэлдэг бөгөөд хамгийн тохиромжтой температур нь 900°C гэж үздэг. Харин ихэнх тохиолдолд үйлдвэрлэлийн нөхцөлд шатаах температурыг 1100-1200°C-ийг дунджаар / 1100 ккал/ бүрэн автомат удирдлагын хяналтын өрөөнөөс тоног төхөөрөмжийг бүрэн хянах боломжтой.



1.4 Шохойн чулууны олборлолт, боловсруулалт

Сөгдөхийн шохойн чулууны ордын тогтоц уул техникийн нөхцөлөөс хамааруулан ил уурхайн аргаар олборлох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд ил уурхайн хүрээ хязгаарыг үйлдвэрийн кондицийн шаардлагыг хангасан В-I зэрэглэлийн нөөцөд тулгуурлан Ил уурхайн эцсийн хүрээ нь дунджаар 450 м урт, 260 м өргөн, газрын гадаргуугаас 80-95 м гүнтэй байна. Төслийн хугацаанд үүсэх ил уурхайн хүрээ нь дунджаар 219 м урт, 222.1 м өргөн, газрын гадаргуугаас 15-20 м гүнтэй байна.

Шохойн чулууг боловсруулах технологийн горимыг туршилтууд, шинжилгээний үр дүнг үндэслэн шохойн идэвх нь 1000 °С температурт шатаахад 81.87%, тунах хугацаа нь 5 минут, туналтын температур 58 °С байж “MNS- 347-2002” стандартын шаардлага хангасан I, II зэргийн шохой гарган авах боломжтой.

Шохой боловсруулах технологийн үндсэн процесс нь шохойн чулууг шатааж нүүрсхүчлийн давхар ислийг ангижруулах урвал юм. Үүнд:

$\text{CaCO}_3 \leftrightarrow \text{CaO} + \text{CO}_2$; $\Delta H = -179$ кДж Энэ урвал нь чулууны нягт, хольцын найрлага, зуухны төрөл зэрэг хүчин зүйлүүдээс хамааран температур, даралтын хэмжээг хэрхэн сонгосноос хамаарна. Онолын хувьд 600 °С-ээс дээш температурт нүүрсхүчлийн кальци задарч эхэлдэг бөгөөд хамгийн тохиромжтой температур нь 900°С гэж үздэг. Харин ихэнх тохиолдолд үйлдвэрлэлийн нөхцөлд шатаах температурыг 1100-1200°С-ийг дунджаар / 1100 ккал/ сонгодог байна. Иймээс технологийн туршилтын дүнг үндэслэн тус ордын шохойн идэвх нь (CaCO₃) нь 1000°С температурт шатаахад 81.87%, тунах хугацаа нь 5 минут байдаг.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОХОЙЛОЛТ

2.1 Болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт

“Шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов. Тус төслийн цаг хугацааны хамрах хүрээ нь жилд 365 хоног ажиллах бөгөөд 2034 он хүртэл олборлолтын үйл ажиллагаа явагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан.. Орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөллийн бүс нь 28.9 га талбай. Уг төслийн нөлөөллийн бүсийг тогтоохдоо нэг талаас төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин үзүүлэх нөлөөллийн газарзүйн тархалт хамгийн их байх орон зайн хүрээг, нөгөө талаас байгаль орчны суурь нөхцөлийн хувьд төслийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх хүчин зүйлийн /үерийн аюул, газар хөдлөлт, хөрсний гулсалт, нуралт гэх мэт/ тархалтын хүрээг тус тус үндэслэв. Лицензийн талбайн нь ерөнхийдөө толгодорхог гадаргатай. Ийм учир шингэн хэлбэрийн эсвэл хатуу хог хаягдал орчинд ялгарах үед ялгаралтын орон зайн хамрах хүрээ нь хязгаарлагдмал байна.

Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь авто машины хөдөлгүүр дэх түлшний шаталтаас үүсэх хийн хаягдал, авто машины хөдөлгөөнөөс үүсэх тоос тоосонцор, дуу чимээ, доргио, уурхайн ухаш, овоолго зэргээс үүсэх тоос тоосонцорюм. Авто машины хөдөлгүүр дэх түлшний шаталтаас үүсэх хийн хаягдал нь 150-200 м зайд тархах бөгөөд үүнээс цааш хүлцэх агууламжаас бага агууламжтай болно. Авто машины хөдөлгөөнөөс үүсэх тоос тоосонцор 10 м/с салхины хурдны үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дундаж хурд 30 км/цаг, тээврийн хэрэгслийн жин 35 тонн /автосамосвалын өөрийн жин 10 тн, ачааны жин 25 тн/ байна гэж үзвэл PM₁₀ тоосонцорын агууламж 1900 м зайд 97.2 мкг/м³ хэмжээтэй байна. 1900 м радиуст тоосонцороос орчны хөрс, ургамлан бүрхэвч, усан орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм. Шохойн чулуу олборлолтын үед эгэл хэсгүүд агаарт ялгарах боломж харьцангуй бага юм.


Овоолгоос үүсэх тоосонцорын хамгийн их агууламж нь эх үүсвэрээс 2000 м зайд ажиглагдана. Үүнээс цааш 8000 м зайд тоосонцорын агууламж 91 мкг/м³ буюу MNS 4585:2007 стандартын утгаас 9 мкг/м³-аар бага байна. Өөрөөр хэлбэл төслийн олборлолтын талбайгаас 7000 м газар нутгийн хөрс, ургамал, мал, амьтан, хүн ам нөлөөлөлд өртөнө. Энэ орон зайн хүрээгээр нөлөөллийн орон зайн хамгийн их хэмжээ тодорхойлогдоно.

Төслийн талбайн ихэнх хэсэг нь 15⁰-аас бага налуутай, гол горхи байхгүй, гуу жалга, харьцангуй бага учир байгалийн үер усны болон хөрсний нуралт гулсалтын аюулд өртөгдөхгүй юм. 7000 м хүрээнд энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх бөгөөд цаашид төслийн үйл ажиллагаанд өөрчлөлт орох нөхцөлд орон зай - цаг хугацаа, үйл ажиллагааны хамрах хүрээнд өөрчлөлт орно. Иймд тухайн үед нь энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт өөрчлөлт

хийлгэх хэрэгтэй. “Шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн ордын ашиглалтын үндсэн процессууд болох үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил, хөрс хуулалтын ажил, Шохойн чулуу олборлолтын ажил, Шохойн чулуу тээвэрлэлтийн ажил, хөрсний гадаад овоолго, тэгшлэлтийн ажил, бэлтгэл ажил зэргээс ургамлан бүрхэвч, хөрсөн бүрхэвч, геологи, геоморфологи зэрэгт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо давхцуулан зураглах аргыг ашиглав. Мөн агаар орчинд тархах тоос, тоосонцор болон бусад төрлийн эгэл хэсэг нь хүндийн хүчний нөлөөгөөр газрын гадаргад бууж хөрс, ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарах бохирдуулагч бодисын тархалтыг тооцоолж, бохирдуулагч бодисын тархалтын хилээр нөлөөллийн бүсийг тодорхойлов. Бохирдуулагч бодисын тархалтыг дараах байдлаар тооцоолов. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийг таамаглаж, учирч болох эрсдэлийг тооцоолж байгаа учир сөрөг нөлөөлөл нь чиг бүрт адил магадлалтай тархана гэж үзэж нөлөөллийн бүсийг татсан.

2.2 Болзошгүй нөлөөллийн тоон үнэлгээний нэгтгэл

Шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн нөлөөллийн хүчин зүйлээр нь авч үзвэл шохойн чулуу олборлох үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн их байна. Хөрсний овоолго нь агаарын чанарт дунд нөлөөлөл үзүүлэх бөгөөд тоосжилтыг дарах зорилгоор филтер шатаах үйлдвэрийн гаргалтын янданд суурьлуулж ус ашиглах усалгааны систем байршуулсан болно. Мөн уурхайн дотоод зам нь тоосжилт ихээр үүсгэх, хөрсний элэгдэл үүсгэх, тосгоноос гарах хатуу, шингэн хаягдал нь хөрс, агаар дахь нянгийн бохирдол үүсгэх эх үүсвэр болно.

	Олборлолтын үйл ажиллагаа		Дотоод зам		Засварын газар		Уурхайн тосгон		Автомашинны зогсоол	
	Э	Ч	Э	Ч	Э	Ч	Э	Ч	Э	Ч
 Агаарын чанар	0	0.00	1	0.13	0	0.00	0	0.00	1	0.13
Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл	3	0.44	1	0.15	1	0.15	1	0.15	1	0.15
Геологийн тогтоц	3	0.23	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Глейрхэг хар хүрэн	0	0.00	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10
Цөлөрхөг хээрийн бор хөрс	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14
Эвдрэлд орсон цөлөрхөг хээрийн бор хөрс	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Толгодын цөлөрхөг хээрийн нимгэн сайр чулуурхаг бор хөрс	3	0.35	1	0.12	0	0.00	0	0.00	0	0.00

Бударгана хөмүүл хялганат бүлгэмдэл	0	0.00	1	0.10	1	0.10	1	0.10	1	0.10
Баглуур таана хялганат бүлгэмдэл	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14
Ургамалгүй	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Баглуур таана хялганат бүлгэмдэл	3	0.35	1	0.12	0	0.00	0	0.00	0	0.00
Газрын доорх усны нөөц горимд үзүүлэх нөлөөлөл	2	0.31	5	0.78	0	0.00	1	0.16	0	0.00
Машин техникийн зорчих хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох ухсан нүх зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	3	0.32	3	0.32	0	0.00	0	0.00	0	0.00
Олборлолтын явцад хөрс хуулалт, газар шорооны ажлын явцад төслийн талбайд тэмдэглэгдсэн мэрэгчид, мөлхөгчид болон шавжийн амьдрах орчин устаж үгүй болох	2	0.25	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00
Уурхай руу татсан өндөр хүчдэлийн шугаманд шувуу үргээгч сэнс, толь, хатгуур суурилуулаагүйгээс үүдэн шувууд хүчдэлд цохиулж үхэх	0	0.00	0	0.00	0	0.00	4	0.35	0	0.00
Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологи байдал	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14	1	0.14

Хүснэгтээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усны нөөц, горим, газрын гадаргын хэлбэршил, хар хүрэн хөрс, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамлан бүлгэмдэл, агаарын чанар, бичил организм зэрэгт үзүүлэх нөлөөлөл их, бусад байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөлөл дунд болон бага ангилалд хамаарч байна. Нөлөөлөгч хүчин зүйлээр нь авч үзвэл олборлолтын үйл ажиллагаа хамгийн их нөлөөтэй байна. Олборлолтын үйл ажиллагаа нь байгалийн хам бүрдэл, геологийн тогтоц зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Хөрсний овоолго нь агаарын чанарт хамгийн их нөлөөлөл үзүүлэх бөгөөд тоосжилтыг дарах зорилгоор ус ашиглана. Мөн геоморфологийн хэлбэршилд өөрчлөлт оруулах эх үүсвэр юм. Дотоод зам нь агаарын чанар сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр, хөрсний шугаман элэгдэл, эвдрэлийн эх үүсвэр болно. Мөн тоосжилтыг дарах зорилгоор ус

ашиглана. Уурхайн тосгоноос хатуу, шингэн хаягдал ялгарах бөгөөд энэ нь хөрсний бохирдол, агаар дахь нянгийн бохирдлын эх үүсвэр, усны бохирдлын эх үүсвэр болно.

2.3 Төсөл хэрэгжилтийн үеийн байгаль орчинд

Үзүүлэх гол нөлөөлөл

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс ил уурхайн аргаар олборлох үед газрын доорх усны нөөц, горим, газрын гадаргын хэлбэршил, хар хүрэн хөрс, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамлан бүлгэмдэл, агаарын чанар, бичил организм зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна Иймд эдгээр нь голлох нөлөөллийн үнэлгээнд байна. Голлох нөлөөллийг тодруулахад:

- Үйл ажиллагааны бохирдлын түвшинг тодорхойлж, харгалзан үзэх;
- Нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг тодорхойлох;

Шохойн чулууны ил уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, тархалтын хэмжээ болон үр дагавар нь харилцан адилгүй юм. Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс улбаалан байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт, хөрсөн бүрхэвч болон ургамланнөмрөг талхлагдах, геологийн тогтоц өөрчлөлтөд орох;
- Олборлолтын явцад дуу чимээний улмаас амьтдын орон зайн тархалт өөрчлөгдөх;
- Төслийг барьж байгуулах үед эдэлбэр газар, хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдах;

Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байрлахын хувьд төслийн гол сөрөг нөлөөллийг:

1. Төслийг хэрэгжүүлэхэд бэлтгэх үеийн
2. Төслийн хэрэгжилтийн үеийн гэсэн үндсэн хоёр хэсэгт авч

Эхнийх нь богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд бөгөөд тэдгээрийн эрч хүч, хамрах хүрээ, хугацаа нь барилгыг барих үеийн удирдлага зохион байгуулалттай холбоотой. Хэрэгжилтийн үеийнх нь төсөл хэрэгжүүлэгчийн өөрсдийн нь үйл ажиллагаатай шууд холбоотой байнгын нөлөөлөл гэж үзэж болно. Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж доорх хүснэгтэд үзүүлэв.

Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Нөлөөллийн голлох хүчин зүйл	Нөлөөлөлд өртөх орчин, объект	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Хөрс хуулалт	Хөрс, ургамал	Уурхайн эдэлбэр	Хүчтэй	Удаан
		Агаар	Уурхайн орчим	Хүчтэй	Богино

		Хөрсний ус	Уурхайн эдэлбэрт	Бага зэрэг	Богино
2	Хүдэр олборлолт, тээвэрлэх ажиллагаанаас тоосжилт үйл үүсэх	Агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц	Уурхайн эдэлбэр, орчны нутаг	Дунд зэрэг	Удаан
3	Ажилчдын суурингаас гарах хог хаягдал	Хөрс	Уурхайн эдэлбэрт	Бага зэрэг	Богино
4	Доргио, дуу чимээ	Хүн ам, ан амьтад	Ажиллагсад, ан амьтан	Дунд зэрэг	Богино
5	Бэлтгэх ажлууд	Агаар, хөрс, ургамал	Ажилчдын сууринг байгуулах хэсэг	Дунд зэрэг	Богино

ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

НЭГ. Агаарын чанар:

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Гарах үр дүн

Хэрэгжилт

-
1. Ил уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох
- Уурхайн үйл ажиллагааны хүрээнд замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хайрган хучилт хийсэн. Төслийн талбайн автозамуудад тоосжилт болон салаа зам гаргахаас сэргийлж, тээврийн хэрэгслийн хурд хязгаарласан болон бусад тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан ба салаа зам гаргахаас сэргийлж замын 2 хажуу талыг 1 метр өндөртэй хамгаалалтын хөмсөг тавьж замаас гарах нөхцлийг хаасан. Төв засмал замаас уурхай хүртэлх 7км замын 2км зам, уурхайгаас кемп хүртэл 1,5км замыг хайрган хучилтаар хучсан. Уурхайд ашигладаг автосамосвалуудын дугуйнуудыг тоос босгох нөхцөл багатай том хээтэй дугуйгаар сольж шинэчилсэн.
-
2. Дулааны зуухны яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах.
- Кемпийн халаалтын зуухыг бүрэн шаталттай үнс , утаа бага ялгаруулдаг, ашиглалтын зардал багатай Галч маркийн 250квт-ын автомат зуухаар сольж ашиглаж байна. Оффисын халаалтыг цахилгаан халаалтын зуухаар сольсоноор яндангүй болсон.
-
3. Хүнд машин механизм, засварын газар, машины зогсоол дахь машин техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл
- Тээвэрт гарах бүрт техникийн үзлэгийг тогтмол хийдэг ба бүрэн бус техникийг ажилд гаргадаггүй. Гаражийн хүрэлцээгүйгээс засварын ажлыг гадаа хийдэг мөн өвлийн улиралд гадаа зогсоодог байсныг зогсоож нэмж 4 машины багтаамж бүхий 24x18 м хэмжээтэй өргөтгөл барьж ашиглалтанд оруулсан. Бүх тээврийн хэрэгсэл, хүнд механизмуудад өвлийн улиралд хөдөлгүүрийг халаах зориулалттай халуун тогоо суурьлуулсан.
-
4. Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх
- Нүүрс тээвэрлэлтийн ажлыг ачааны вагоноор авдаг болсон бөгөөд Өргөн өртөөнөөс өөрийн автосамосвалаар тээвэрлэдэг болсон. Олон

машин явах шаардлагагүй болсон бөгөөд богиноны рейсэнд явж байгаа самосвалд бага ачдаг болсон бөгөөд асгарах эрсдэл багассан. Олон салаа замаар явахгүй нэг замаар явдаг болсон.

Хоёр. Усны нөөц чанарын асуудал

Гарах үр дүн

Хэрэгжилт

- Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхайн үйл ажиллагаанд усыг урт хугацаанд хэмнэлт, дахин ашиглалтгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах

Уурхайн хэмжээгээр унд ахуйд 135,2м³ мод усалгаанд 630,0 м³, тоосжилт дарахад 1080м³ ус хэрэглэх тооцоо гарсан нь өмнөх онуудад хэрэглэсэн нийт хэмжээнээс илүү гараагүй. Кемпийн ногоон байгууламжийн усалгаа болон ахуйн хэрэглээнд 50 тн-ын нөөцийн саванд нөөцөлж зохистой хэрэглээ бий болгосон. Жилд 2 удаа нийт ажилчдад ХАБЭА болон Байгаль орчны талаар сургалт явуулдаг ба усны зохистой хэрэглээ ашиглалтын талаар сургалт, зааварчилга оруулсан. Уурхайн тоосжилт дарах зорилгоор гадаргын ус хуримтлуулах цөөрөм үүсгэж хуримтлагдсан усаар замын тоосжилт дарахад ашигладаг.
- Зэрлэг ан, амьтан уух усгүй болох.

Уурхайн бүсээс 17км зайд байрлах Сүмийн булагийг эхийг цэвэрлэж лайдаж ундрага болон урсацыг нэмэгдүүлэн булгийн эхийг

мал, амьтан орохоос сэргийлж 10 метрийн диаметртэй төмөр тор бүхий хашаа барьж хамгаалсан. /зураг/

3. Ундны усны чанар алдагдах

Унд ахуйд ашигладаг худгийн хажуугийн гол зуны улиралд үерлэж худгийн орчны хөрсийг урсгахаас сэргийлж үерийн хамгаалалтын далан барьж худагт үерийн ус орохоос хамгаалсан. Худгийн байрыг тохижуулж худагт элдэв зүйл орох нүх сүвийг хааж битүүмжилж эрүүл ахуйн аюулгүй бүс тогтоож хамгаалалтын хашаа барьсан

Гурав. Хөрсний чанар:

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Гарах үр дүн

Хэрэгжилт

1. Хөрсөнд шатах, тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх

Ажилд гарах болон тээвэрт гарахын өмнө машин техникийг үзлэгийн хуудсаар шалган шаардлага хангахгүй машин техникийг ажилд гаргахгүй эвдрэл гэмтлийг засварлаж дууссаны дараа ажилд гаргадаг. Гараж хүрэлцээгүйгээс ил зогсоолд машин байрлуулж засварладаг байсныг болиулж засварын Workshop-ыг 7 машины багтаамжтай байсныг 11 машин байрлуулах багтаамжтай болгож өргөтгөж томруулсан. /зураг/

2. Кемпийн хашаан дотор хөрсний элэгдлийг бууруулах зориулалтаар явган хүний замын хажуу талаар ногоон зүлэгжүүлэх, мод тарих

Кемпийн авто зогсоолын талбайг багасгаж, зогсоол амрах байрыг холбосон явган зам байгуулж, хажуу талаар зүлэгжүүлж, цэцэг тарьдаг. Ажилчдын хотхонд нийтдээ 1000м2 талбайд зүлэгжүүлж, 300ш мод шинээр үрслүүлж тарьсан.

3. Газрын хэвлийн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Кемпийн бохирын сав дүүрч асгарах хөрс бохирдуулахаас сэргийлж тусгай зориулалтын машинаар сар бүр соруулж, саван дахь бохирыг савны 60%-с хэтрүүлдэггүй. Соруулах үйл явцыг сайжруулж шүүлтүүртэй насосоор шахаж бохирын машинд юүлж, тээвэрлэн асагадаг. Зуны улиралд өнгөн хэсгийн саарал усыг мод усалгаанд ашигладаг.

4. Цөлжилт, хуурайшилт

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд энэ онд 300 мод, бут шинээр тарьсан. Ирэх онуудад тарихаар нийт 2000 орчим хайлаас, сухай үрслүүлэн тарьц бэлтгэж байна.

Дөрөв: Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар:

Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Гарах үр дүн	Хэрэгжилт
1. Цахилгаан дамжуулах шугаманд суурьлуулсан шувуу үргээгчийг шинэчлэх /10ш/	Хамрын хийдээс уурхай хүртэл цахилгаан дамжуулах шугамд үзлэг хийхэд гацсан эвдэрсэн 70 ш шувуу үргээгчийг шинээр сольсон .
2. Уурхайн нийт ажилчид болон тээврийн жолооч нарт зэрлэг ан амьтан нүүдэллэх, ороо орох, бэлчээрлэх тээврийн замыг хөндлөн гарах үеэр зам тавьж өгөх зэрлэг ан амьтныг хайрлан хамгаалах талаар сургалт орох	Байгаль орчныг хамгаалах, талаар ажилчдын 2 удаагийн сургалт зохион байгуулж нийт ажилчдыг хамруулсан. Төслийн бүсийн орчмын замд хурдны хязгаар болон дуут дохио өгөхийг хориглосон тэмдэгүүд байрлуулсан.
3. Ган гачигдал болж ан амьтан уух усгүй болох	Энэ жил бороо хур ихтэй байсан учир ган болоогүй. Уурхайн орчмын голын сайранд үүсмэл цөөрөмийг зэрлэг ан амьтан, малд

зориулж гаргасан. Сүмийн булгийн хамгаалалтын хашааг цэвэрлэж ундрагыг нэмэгдүүлэх зорилгоор шавар шороог лайдаж урсацыг нэмэгдүүлсэн.

3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Манай уурхай нь шохойн чулуун уул хэлбэрийн тогтоцтой тул хөрс хуулалт байхгүй. Уурхайн ашиглалтын явцад уурхайн хил дотор техникийн болон биологийн нөхөн сэргээлт байхгүй бөгөөд уурхайн олборлолт болон бүтээгдэхүүн борлуулалт үйлдвэрийн бүтээн байгуулалтийн санхүүжилтийг нөхөх, ашигт ажиллагаа зэрэгт үндэслэн уурхайн ашиглалтын 2024 онд дүйцүүлэн хамгаалах байдлаар нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ гэж төлөвлөсөн учир 2024оны төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажлыг дүйцүүлэн хамгаалах замаар хийсэн учир биелэлт гаргах боломжгүй байна. Иймээс нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн оноог бусад ажил руу шилжүүлэн тооцож өгнө үү.

3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уул уурхайн олборлолттой холбоотой үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийн ажил түүнтэй дүйцэхүйц хэмжээний ажлыг өрнүүлсэн ч хэзээч байгалийн унаган төрхөнд нь хэзээч оруулж чаддаггүй ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм.

1. **Өргөн сумын нутагт эзэнгүй орхигдсон эвдэрсэн нүх, овоолсон шороог аюулгүй байдлыг хангах зорилгоор тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт актаар хүлээлгэн өгөх.**

Өргөн сумын төвд нураасан барилгын суурь, барилгын хаягдлыг зайлуулахад автосамосвалаар хангасан 50м³ хог зайлуулсан. Мөн тус сумын 1-р багийн нутаг Хавцгай нэртэй газар эзэн холбогдогчгүй эвдэрсэн 2,7888 га талбайг техникийн нөхөн сэргээлт хийхээр зохих байгууллагад хүсэлт гарган зөвшөөрөл авсан. 2023онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ шинэчлэж батлагдаагүй байсан тул Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах боломжгүй байсан тул 2023онд хийсэн дүйцүүлэн нөхөн сэргээлт хийсэн ажлыг шилжүүлэн тооцуулах хүсэлтэй байгаа билээ. менежментийн оноос үе шаттайгаар 5 жилийн хугацаанд техникийн нөхөн сэргээлтийн ажил эхлүүлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн. Энэ жил хур хогийг овоолж, хүн мал, амьтан унахаас сэргийлж хамгаалалтын даланг сэргээж, зам талбайг зассан.

3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хувьд уул хэлбэрийн геологийн тогтоцтой бөгөөд уурхайн олборлолтын хэсэг, үйлдвэрийн хэсэг, уурхайн тосгоны уурхай ашиглахаас өмнө нь болон одоогийн байдлаар газрын маргаан байхгүй бөгөөд Ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдаагүй болно.

3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга Хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт
Уурхайн үйл ажиллагааны үед археологийн болон палентологийн ховор дурсгалт олдворууд илэрч болзошгүй	Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед археологи, палентологийн ховор түүхийн дурсгалт зүйл илэрвэл холбогдох төрийн байгууллагад заавал мэдэгдэх	Уурхай ашиглалтын явцад түүхийн олдвор илрээгүй. Хэрэв түүх, соёлын олдвор илрэх тохиолдолд холбогдох төрийн байгууллагад нэн даруй мэдэгдэх бөгөөд энэ талаарх ерөнхий мэдээллийг ажилчдад олгох, мэдээлэл өгөх ажлыг нийт 35 ажилчинд 2 удаа сургалт зохион байгуулсан.

3.6 Осол эрдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл бий болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.
2. Автозасварын газар, үйлдвэрийн оффис, уулын хэсэг, кемпийн амрах байр, техник тоног төхөөрөмж, авто машин зэрэг газар галын хорыг шинэчлэх, галын хорыг байрлуулах.	-4кг галын хор 24ш-г цэнэглүүлж, 12ш шинээр худалдан авсан. - -25кг дугуйтай галын хор 1ш цэнэглүүлж, 1ш шинээр авсан. -1 кг 12ш шинээр худалдан авч байрлуулсан.

<p>3. Аюулгүй байдлын үүднээс амрах байр болон үйлдвэрийн оффисын барилгад галын дохиололын батерейг солих, ажиллагааг шалгах</p>	<p>Нийт 9в-ын 12ш батерейг сольж найдвартай ажиллагааг шалгасан.</p>
<p>4. Цахилгааны аюулгүй ажиллагаа, системийн найдвартай аюулгүй байдлыг сар тутамд тогтмол үзлэг шалгалт хийх</p>	<p>Дотоод хяналт шалгалтын комисс болон ХАБЭА-нэгж сарын тогтмол үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийгтухай бүрт нь арилган осол, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авдаг.</p>

3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Авч хэрэгжүүлэх ажил	гүйцэтгэл
<p>Үйлдвэрийн болон ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорх ус бохирдуулах сөрөг нөлөөтэй</p>	<p>-Үйлдвэрийн болон ахуйн хаягдлыг гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах, зориулалтын цэгт хогийн сав байршуулах</p> <p>-Дахин ашиглах, боловсруулах боломжтой хаягдлуудыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах</p> <p>-Машины хуучин дугуйг мал бүхий иргэдэд өвөлжөө барихад нь туслах зорилгоор өгөх</p>	<p>Хог хаягдлын талаарх сургалт, мэдээллийг нийт ажилчдад 3 удаа зохион байгуулж, анхан шатны мэдэгдэхүүн олгож, хог хаягдлын хор нөлөө, дахин боловсруулах, ангилан ялгах таних тэмдэг, зориулалтын савнуудыг гал тогоо, уурхайн хотхон, боловсруулах үйлдвэр, өөр бусад шаардлагтай газар 4 нь сав байрлуулсан. Уурхайгаас гарсан хаягдал төмөрийг 2 удаа төмөр авдаг хүмүүст тусаасан бөгөөд хаягдал төмрийн цэгийг цэгцэлэн хураасан болно. Мөн авто машинаас гарсан хуучин муу дугуйг тусад нь ангилан хурааж байгаа болно.</p>
	<p>-Үйлдвэрээс гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан бетонон</p>	

Ахуйн аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй.	хучилттай хашаанд хадгалах , хаягдал боловсруулах газарт өгөх	
	Хэрэглэсэн батерей, принтерийн хор, ахуйн аюултай хог хаягдлыг битүүмжлэл сайтай хадгалах	Үйлдвэрийн засварын цэг, авто машины зогсоол болон бусад хүчин зүйлээс шалтгаалан шатах тослох материалаар бага хэмжээгээр хөрс бохирдсон 3 удаагийн тохиолдол гарсан бөгөөд тухай бүр хөрсийг тос нэвчсэн 5-7 см гүнтэйгээр хуулан авч хог хаягдлын түр цэгт төвлөрүүлэн, саармагжуулах ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу гүйцэтгэв.
Хог хаягдлын төлбөр хураамж	2022оны хог хаягдлын төлбөрийг холбогдох дансанд шилжүүлсэн болно.	

3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны хүчин зүйл	Хяналт, үзүүлэлт	Байршил	давтамж	Гүйцэтгэл
Агаарын чанар				
Уул, техникийн ажлын явцад тоос босож агаар бохирдох машин механизмын	CO ₂ , NO ₂ , SO ₂ , тоос нийт (PM ₁₀ , PM 2.5) Дуу чимээ, шуугиан, доргио	Ил уурхайн салхины чиглэл доор тус бүр 1 цэг Уурхайн гадаад тээврийн замаас салхины доод талд 1 цэг Уурхайн тосгон 1 цэг	Дорноговь аймгийн УЦУОША-ны лаборатори орчны нэмэлт шинжилгээг хийж агаар, ус, хөрснөөс сорьц авч шохойн чулууны үйлдвэр SO-0.008мг\м3, Карьер-0.003мг\м3, Тээврийн зам 0.004мг\м3, Кемп SO-0.450мг\м3	

хорт хий ялгарах	Шохойн чулуу зэргийн орчны нөлөөллийн боловсруулах үйлдвэрийн салхины доод тал 1 цэг
------------------	--

Хөрсөн бүрхэвч

Шатах тослох материал, хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний механик бүтэц, хими физикийн шинж чанар, бохирдол, нефтийн бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын цэг 1 цэг - ШТМ-ын агуулах 1 цэг - Шимт хөрсний овоолго 1 цэг 	<p>Гол ионы шинжилгээ, хөрсний агрохимийн шинжилгээ, агаарын том ширхэдвгт pm10 тоосонцор, хүхэрлэг хийн агууламж, азотын давхар исэлийн агууламжыг тодорхойлов.</p> <p>Дээрх агаар, хөрс, усны гол ионуудын харьцааг тодорхойлсон шинжилгээний дүнгээс үзэхэд заагдсан стандарт дахь хүлцэх агууламж (цаашид ХА гэх)-аас давсан бохирдолгүй байна.</p>
--	---	--	---

Усан орчин

Хөрсний бохирдлоор дамжин газрын доорх ус бохирдох	Усны чанарын үндсэн үзүүлэлт болон анион, катион, хүнд металл	<ul style="list-style-type: none"> - Уурхайн худаг 1 цэг - Хаягдал ус 1 цэг 	<p>Усан орчин PH.-8.6</p> <p>Цахилгаан дамжуулах чанар EC-831\см, Кальцийн ион мг\л 30.5 Са, Fe-0.12мг\л, F-3.18мг\л, Хатуулаг 3.31, Сульфатын ион 32.6мг\л, Магнийн ион-21.7 мг\л, Эрдэсжилт-564.9мг\л, Фосфор 0.068мг\л, Жинлэгдсэн бодис 6.4 зэргээр тус оны 5-р сар болон 9-р сард Дорноговь аймгийн УЦУОШГ-р хийлгэсэн болно.</p>
--	---	---	--

3.9 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийлгэх	Мейк Грийн ХХК тай гэрээ байгуулсан. Боловсруулах шатанд байгаа.
Ажилчдын хөдөлмөр хамгаалалын ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах	Бүх ажилчдад бүрэн 2 ээлжийн өвөл , зуны хувцас хамгаалах хэрэгсэл олгосон.

3.10 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Сумын фэйсбүүк групп-д үйл ажиллагааны талаар, хийсэн ажлын талаар тайлагнасан. Мөн орон нутгаас шинээр 3 ажилтан ажилд авсан. Нийт орон нутгаас 11 хүн ажилдаг болсон. Орон нутгийн иргэдээс гомдол одоогоор ирээгүй. Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. 2 малчин айлд том машины хэрэгцээнээс гарсан дугуйг өвөлжөө барих зорилгоор 100ш дугуйг олгосон. Мөн уурхайн ойр орчимын мал бүхий иргэдэд өвлийн хэрэгцээнд нь зориулж 1тн нүүрс үнэгүй олгосон.

ТАВ ДҮГНЭЛТ

Сөгдөхийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны үйл ажиллагааны хугацаанд усны нөөцийг үр ашигтай зарцуулахад анхаарч холбогдох журмын дагуу гүний худгийг бүрэн тоолууржуулж, холбогдох байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу унд ахуйн шугамыг эрүүл ахуйн стандартад нийцсэн цайран цагаан турбагаар 254м шугамыг шинээр татан халдаг дулаан утсаар ороож гадуур нь дулаалгын хөөсөн хамгаалалт хийсэн болно. Усны дүгнэлт болон зөвшөөрлийн дагуу ашигласан усны төлбөрийг барагдуулан, төслийн дотоод, гадаад авто замуудад хурдны хязгаар, чиглэл заасан тэмдэг, дуут дохио дугарахыг хориглосон тэмдэг суурилан зарим талбайг хайрган хучилттай болгож кемп орчимд усан оргилуур, цэцгийн мандал, өнгөлгөөний хавтангаар явган хүний замыг барьж байгуулсан байна.

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоох, саармагжуулах, урьдчилан сэргийлэхэд ихээхэн анхаарч ажилласан. Тухайлбал агаар, ус, хөрсний шинжилгээг Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний албаар хийлгэж, ахуйн хог хаягдал, үйлдвэрийн хог хаягдал, тос тосолгооны материалын хаягдал зэргээс хөрс бохирдохоо урьдчилэн сэргийлэх, энэ чиглэлийн мэдлэгийг албан хаагчдад таниулах ажлыг 3 удаа зохион байгуулж, зориулалтын хатуу, шингэн хаягдал, тосны хаягдлыг цуглуулах цэг байгуулж, хаягдлыг нийлүүлэх талаар холбогдох байгууллагуудтай холбогдон Мера ХХК-ний тэсрэх материалын үйлдвэрт нийлүүлэхээр эхний тохиролцолд хүрсэн ба одоогоор уурхай дээрээ бетонон тавцан дээр поошигонд хурааж байгаа болно. Мөн бид 2023онд Эковишн ХХК-аар байгаль орчины аудит хийлгэсэн бөгөөд зөвлөмжийн дагуу БИО 00 2 ширхэгийг, ШТС-ын талбайг бетондсон болно. Мөн бид цаашид хийж хэрэгжүүлэх, анхаарах зүйлсийн талаар нэгдсэн ойлголтонд хүрч дараа дараагийн төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөж байна.

Хавсралт

1. Барьцаа хөрөнгө байршуулсан баримт

Огноо/Date: 2024.05.29 16:25:44

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No: 000759116636

Системийн огноо/System Date: 2024.05.29 16:25:44

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5034910561	Ж****А ОЮУН-ЭРДЭНЭ	4,620,000.00 MNT	1.00
/ Дөрвөн сая зургаан зуун хорин мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр/Bank Name State Fund - Төрийн Сан		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 100900013406	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	4,620,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Нөхөн сэргээлтийн баталгаа Ялгуунинтернэшнл А2425

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

Ас
Гф

2. Усны төлбөр төлсөн баримт



Огноо/Date: 2024.08.06 08:24:28

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 2358089

Системийн огноо/System Date: 2024.08.06 08:24:28

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5034910561	Ж****А ОЮУН-ЭРДЭНЭ	1,232,537.00 MNT	1.00
/ Нэг сая хоёр зуун гучин хоёр мянга таван зуун гучин долоон төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 05	Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	1,232,537.00 MNT	1.00
	5176120446	МТА.ТАТВАР		

Гүйлгээний утга/Transaction description:

3240123016627; УС74030700; 99052109

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

Ac
Go



2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/195

Сэнж

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, 28.6 дахь заалт, 28.11 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан "Усны нөөц ашигласны хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай" 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 7 дахь заалт, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 327 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 18 дахь заалт, Байгаль орчин Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дүгээр тушаал, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн "Ус ашиглуулах дүгнэлт" 38 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2024 онд ус ашиглах дүгнэлт гаргуулсан "Ялгуун интернэйшнл" ХХК-д усны дүгнэлтэд заасны дагуу ус ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Усны тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг гэрээнд заасан үүргийн дагуу биелүүлж ажиллахыг "Ялгуун интернэйшнл" ХХК-ийн Захирал (А.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

3. Ундны усыг ашиглах талаар гэрээний биелэлтэд хяналт тавьж, зөрчил дутагдлыг дор бүр нь арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны бодлогын мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч (Э.Баярсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.БАЯРБОЛД



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 09 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 2

Өргөн сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалтыг үндэслэн: **Ус ашиглуулагчийг төлөөлж** Дорноговь аймгийн Өргөн сумын нэртэй (дугаартай) худгийн эзэмшигчийг төлөөлж **Сумын Засаг дарга** албан тушаалтай **Г.Баярболд**,

Ус ашиглагчийг төлөөлж: Дорноговь аймгийн Өргөн сумын 1-р баг хаягт орших, **2569477** регистрийн дугаартай **“Ялгуун интернэшнл” ХХК**-ийг төлөөлж **А.Баярсайхан** нар дээр худгаас ус авч ашиглах талаар тохироцон энэхүү гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөөрс 2024 оны 12 дугаар сарын 31-ний хүртэл хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт: **Өргөн сумын нутагт орших MV-002425 тусгай зөвшөөрөлтэй Сөгдөхийн шохойн чулууны орд ашиглах**

2.2. Ашиглах усны хэмжээ:

- 2.2.1. унд-ахуй, м³/хоног 177 м³
- 2.2.2. үйлдвэрлэл, м³/хоног 4752.0 м³
- 2.2.3. үйлчилгээ, м³/хоног 3696.0 м³
- 2.2.4. эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.3. Усны чанар, найрлага

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: **Өргөн сумын нутагт орших MV-002425 тусгай зөвшөөрөлтэй Сөгдөхийн шохойн чулууны үйлдвэр**

Солбицол	X	Y
	110 29 40.85	44 36 58.57
	110 29 15.86	44 36 58.57
	110 29 15.86	44 37 15.57
	110 29 40.85	44 37 15.57

Хүчин чадал, Барилга байгууламж: УГЦ-1 худаг 108 35 29,7, 43 36 10,3 координатад байрлах бөгөөд статик түвшин 10,0 м гүн нь 58,0м, 2.0л/сек ундрагатай. Кемп-2 худаг 108 36 46,6, 43 40 15,1 координатад байрлах бөгөөд статик түвшин 3.44, гүн нь 100м, 2.0л/сек ундрагатай.

Тоног төхөөрөмжийн нэр, марк: УГЦ-1, Кемп-2 худагт Ingersoll “RAND-900” маркын компрессор суулгасан.

2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил: N44° 37' 38,4", E110° 28' 47,5"

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: 1.5 кг/м³

2.7. Усны тоолуурын: **Эзэмшлийн 1 худагт тоолуур суурилуулан ашигладаг**

2.8. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

1832.537.0 (Нэг сая хоёр зуун тусин хоёр мянган таван зуун тусин гучин долоон долоон)

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.3. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА

 Г. БАЯРБОЛД

Хаяг: ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН
СУМ 4-Р БАГ

Харилцах утас: 91912258

Ус ашиглагчийг төлөөлж:

“ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК

 А. БАЯРСАЙХАН

ХАЯГ ДОРНОГОВЬ АЙМАГ, ӨРГӨН 1-Р
БАГ

Харилцах утас: 99093121



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
А-157 тоот тушаалын 2 дугаар хавсралт

УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар 1

Зорисловь аймгийн Тамгас орчин, аймаг туушаалагч газар -ын
/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба/

гаргасан 2024 оны 07-р сарын 23-ны өдрийн 38 дугаартай ус ашиглуулах дүгнэлт,

Ормон сумын Засаг дарга А195 тоот захирагч -ын
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга/

олгосон 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл,

Ормон сумын Засаг дарга -тай
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, Ус хангаач байгууллага/

2024 оны 09-р сарын 10-ны өдөр байгуулсан 0.2 дугаар бүхий ус

ашиглах гэрээг үндэслэн Зорисловь аймаг, нийслэл,

Ормон сум, дүүрэг Сүмийн буюу баг, хорооны
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг/

нутагт байршилтай, улсын бүртгэлийн 90 НН 07057 тоот гэрчилгээтэй,

2569477 регистрийн дугаартай Ялгуун интернэшнл ХХК-г
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж, 1х байт

байршилтай усны нөөцөөс хоногт 70 м шоо метр усыг
/гадаргын ус, газрын доорхи ус/

Унд, мэд, усааа, тос, снмт зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг гурван жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгосон:

Зорисловь аймгийн Ормон сумын ЗОБМ-ын А.Валерийн
аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалагч

/байгууллага, албан тушаалтны нэр, гарын үсэг/



20 24 оны 09-р сарын 10-ны өдөр



“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ХХК
УСНЫ ТООЛУУР ХОЛБОЛТ, УГСРАЛТЫН АКТ

.....-д ашиглаж байгаа
 LXSGR марк 20230336 дугаар 32 голчтой 0000 заалттай хүйтэн усны тоолуурын холболт, угсралтын ажлыг хийв.

Тоолуурын холболт, угсралтыг хийсэн:

Усны тоолуурын техникч  /Б.Эрдэнэбат/
 (гарын үсэг) (овог нэр)

Засварчин  /
 (гарын үсэг) (овог нэр)

Хүлээн авсан: /
 (гарын үсэг) (овог нэр)

2024 оны 02-р сарын 17-ны өдөр

 СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
№ ЭУ120106.....

.....-д
 (хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXSGR загварын 10 м³/ц м³/ц
 хэмжих хязгаартай 32 мм-ийн голчтой № 202303366 -ын
 халуун, хүйтэн усны тоолуурыг № 018 лацаар битүүмжилж
 (доогуур зурах)
 2025 оны 12 -р сарын 06 -ны өдөр хүртэл улсын
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 00000 м³


 Улсын шалгагчийн
 гарын үсэг, тэмдэг

 Лабораторийн тэмдэг
 2023 оны 12-р сарын 06 -ны өдөр



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 01

Орбэ-вош далавдал говийн сав газрын дэлгэцэ -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 2024/15 тоот

дүгнэлтийг үндэслэн Дорноговь аймаг/нийслэл Орхон

сум/дүүргийн Сүхийн Оуул Гол байршилтай
/ хаяг /

Согдон шалган үзүү
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа Агуун итгэртэй ххк -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /

Дорноговь аймаг/нийслэл, Орхон сум/дүүргийн

1р Ош логийн цэс байршилтай хаягдал

ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны
шугамд жилд 540 мян.м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа

орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”,

“Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд

нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар

тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг

/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон

дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.

Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны

шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

Орхон сумын ЗСТТ
/ Зөвшөөрөл олгосон байгууллага /

А.Байрмун
Гарын үсэг

А.Байрмун
/ Гарын үсгийн тайлал /

Тамга

2024 оны 09-р сарын 10-ны өдөр

БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН
СУМЫН ЗАСАГ ДАРГА


Г.БАЯРБОЛД

БАТЛАВ:
“ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


А.БАЯРСАЙХАН
ДОРНОГОВЬ АЙМАГ

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА
ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ
ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2024 оны 09 сарын
10-ны өдөр

Дугаар 1

Өргөн сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн сунгалтыг үндэслэн:

Нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж **Өргөн сумын Засаг Даргын Тамгын газрын байгаль орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч Э.Баярсүрэн** нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж **Дорноговь аймаг, Өргөн сум, 1-р баг, 9011107057** тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, **2569477** тоот регистрийн дугаартай **“Ялгуун Интернэшнл” ХХК-ийн захирал А.Баярсайхан** нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1.1 заасны дагуу хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр төлбөрөөс чөлөөлнө, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.Т

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

- 2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;
- 2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;
- 2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;
- 2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;
- 2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.
- 2.4.7. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ 40,500 (Дөчин мянга таван зуу)

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

- 3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.
- 3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;
- 3.3. Сав газрын захиргаа нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.
- 3.4. Сав газрын захиргаа нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

- 4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.
- 4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.
- 4.3. Хаягдал ус тоолууржуулах журам батлагдаагүй байгаа тул өөрийн ашиглаж буй тоолуурыг ашиглана. Уг хаягдал усны тоолуур нь гаргалгаан дээр, гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцсэн байх.

Тав. Бусад

- 5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Дорноговь аймаг Өргөн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин уул уурхай бодлого хариуцсан мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч



Э.Баярсүрэн

Хаяг: Дорноговь аймаг, Өргөн сум 4-р баг
Харилцах утас: 88049952

Ус ашиглагчийг төлөөлж:

“Ялгуун-Интернэшнл” ХХК-ийн Байгаль орчин нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн



Э.Пүрэвдорж

Хаяг: Дорноговь аймаг, Өргөн 1-р баг
Харилцах утас: (976) 88555035

БАТЛАВ:  УЛААНБААТАР ХОТ
“ХАЙ БИ ОЙЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.АМАР-ОТГОН

БАТЛАВ:  УЛААНБААТАР ХОТ
“ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
З.НАЦАГДОРЖ

ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС
НИЙЛҮҮЛЭХ, ХҮЛЭЭН АВАХ ГЭРЭЭ

2024 оны 08-р сарын 06-ны өдөр

№ 24/19

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Хай Би Ойл” ХХК-г төлөөлж менежер ажилтай Л.Даваагэрэл, /цаашид хог хаягдал хүлээн авагч/ нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2569477 тоот регистрийн, 9011107057 тоот улсын бүртгэлийн дугаартай “ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК-ийн СӨГДӨХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙ-г төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн ажилтай Э.Пүрэвдорж /цаашид хог хаягдал нийлүүлэгч гэх/ нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Иргэний хуулийн 189 дүгээр зүйл болон Хог хаягдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн хаягдал тосыг нийлүүлэх, хүлээн авах гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

- 1.1 Энэхүү гэрээгээр хог хаягдал нийлүүлэгч буюу засвар үйлчилгээний төвийн /цаашид ЗҮТ гэх/ үйл ажиллагаанаас үүссэн машин механизм, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарсан техникийн хаягдал тос болох аюултай хог хаягдал /цаашид “АХХ” гэх/-ийг хаях, түүнтэй холбоотой холбогдох үйлчилгээний хөлө төлөх, Хог хаягдалыг хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг хүлээн авахтай холбоотой тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг хариуцах болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой хэцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
- 1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн аар 2025 оны 4 сарын 01 -ний өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлдэггүй гэж үзсэн тохиовдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.

- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэл ирүүлж сунгана.
- 2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, тээвэрийн хэрэгсэлд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг “Ялгуун интернэшнл” ХХК-ийн ЗҮТөв нь ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.4 “Хай Би Ойл” ХК нь “Ялгуун интернэшнл” ХХК-ийн ЗҮТөвийн үүсгэсэн АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар бэлтгэн нийлүүлэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.
- 3.5 Аюултай хог хаягдал нийлүүлэгч буюу “Ялгуун интернэшнл” ХХК нь АХХ-н тээвэрлэлт, аюулгүй ажиллагаа, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, хог хаягдал хүлээн авагчид өөрийн зардлаар тээвэрлэн хүргэж өгөх үүрэгтэй. “Ялгуун интернэшнл” ХХК нь ачих, тээвэрлэх үедээ хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах ба аюулгүй ажиллагааг хангаагүйгээс үүдэн “Хай Би Ойл” ХК болон бусад гуравдагч этгээдэд хохирол учруулбал бие даан хариуцан барагдуулна.
- 3.6 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэж санхүүгийн анхан шатны баримт үйлдэн баталгаажуулах үүрэгтэй.
- 3.7 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.8 Хог хаягдал нийлүүлэгчийн нийлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага хог хаягдал хүлээн авагчид шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлыг “Хай Би Ойл” ХК нь хэрхэн ашиглах, ашигласан нь “Ялгуун интернэшнл” ХХК-нд үл хамаарна.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 4.1 Хог хаягдал нийлүүлэгч нь өөрийн үүсгэсэн аюултай хог хаягдлыг хүлээн авах дахин боловсруулах, устгахтай холбогдон гарах зардалд шаардагдах үйлчилгээний хөлс төлөх үүрэгтэй бөгөөд энэхүү үйлчилгээний хөлс нь **нэг тонн тутам нь 150'000₮ (нэг зуун тавин мянга)** төгрөг байна. /НӨАТ багтсан болно/
- 4.2 Хог хаягдал хүлээн авагч нь нийлүүлсэн АХХ-ын хэмжээг талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтын бичилтийг үндэслэн тооцоог гаргаж, нэхэмжлэлийг хүргүүлнэ.
- 4.3 Хог хаягдал нийлүүлэгч нь АХХ-н үйлчилгээний хөлсийг тооцоо нийлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор хог хаягдал хүлээн авагч болох “Хай Би Ойл” ХК-ийн **Худалдаа хөгжлийн банк банкны 405025812** тоот дансанд шилжүүлнэ.

- 4.4. Хог хаягдал нийлүүлэгч нь гэрээгээр тохирсон хугацаандаа АХХ-ийн үйлчилгээний хөлсийг төлөөгүй тохиолдолд хог хаягдал хүлээн авагч нь дахин АХХ-ийг хүлээн авахгүй бөгөөд талуудын байгуулсан гэрээг дангаараа цуцална.

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.
- 5.3 Дээрхээ шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
- 6.3 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Хай Би Ойл” ХК-ийн

Менежер Л.Даваагэрэл




/гарын үсэг/

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Ялгуун интернэшнл”ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн Э.Пүрэвдорж



/гарын үсэг/

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо,
Сонсголон /18135/, Товчооны 59 тоот.
Утас: 99904034, 80010277
Цахим шуудан: davaagerel@hboil.mn

Монгол улс, Дорноговь аймаг, Өргөн сум, 1-р
баг, Сөгдөх уул, Сөгдөхийн шохой боловсруулах
үйлдвэр
Утас: 95447077, 88555035
Цахим шуудан: Yalguunlime@gmail.com
Purevdorj555@gmail.com



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1,20.2, Сумын ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 08 тоот тогтоолыг үндэслэв.

1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

2.1 Нэг талаас Дорноговь аймгийн Өргөн сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны бодлогын мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч А.Рэнцэнханд нөгөө талаас 9011107057 тоот улсын бүртгэлийн дугаар 2569477 тоот регистрийн дугаартай Захирал Адьшаагийн Баярсайхан нар харилцан тохиролцож 2024 оны 01 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25 хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

3.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хуулийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.2 Аж ахуй нэгж байгууллагын барилгын хог хаягдал гаргасан хураамжийг Сумын ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 08 тоот тогтоолоор Ахуйн хэрэглээний хог хаягдал /уул уурхай/ сарын 30000 төгрөгөөр тооцно.

Дөрөв. "Ялгуун интернэшнл" ХХК-ийн хүлээх эрх үүрэг

4.1 Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

4.2 Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны хураамжийг сумын төрийн сан банкны 100060700947 тоот дансанд бүрэн төлөх

4.3 Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдлыг 7 хоног бүрийн 3 дахь өдөр сумын тамгын газарт мэдэгдэж ачуулах.

4.4 Төлөх нийт төлбөр: 1 сарын 30000 төгрөг

Нийт төлбөр: 360000 /гурван зуун жаран мянган төгрөг/

4.5 Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.

4.6 Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг Сумын ЗДТГ-т мэдээлж байх.

4.7 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт суртчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.

4.8 Аюултай

хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.

4.9 Барилгын хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө төлөөгүй болон ил задгай шатаасан, зориулалтын бус газар хог хаяг хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгуулах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.2 Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Дорноговь аймгийн Өргөн сумыг төлөөлж

Байгаль Орчны Бодлогын Мэргэжилтэн

 А.Рэнцэнханд

Утас: 95826536

Ердийн ашигт малтмал ашиглагчийг төлөөлж

"Ялгуун интернэшнл" ХХК-ийн

Захирал  А.Баярсайхан -2

Утас: 99093121

БАТЛАВ.
“ТҮМЭН ЭГШИГ” ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Т. ЧИНЗОРИГ /
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ
2024 оны 8 сарын 12 ний өдөр № 224/812 Улаанбаатар хот

БАТЛАВ.
“ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ” ХХК
ЗАХИРАЛ

З. НАЦАГДОРЖ /

Нэг талаас Түмэн эгшиг ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр, Нөгөө талаас Ялгуун интернэшил ХХК-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн албан тушаалтай Э.Пүрэвдорж бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-г тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисны шинж чанарт тохирсон үүсмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2024 оны .. сарын .. өдрөөс 2025 оны ... сарын .. өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлоно.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлно.
- 3.7. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгсөнөөс хойш ажлын 10 хоногийн дотор Түмэн этшиг ХХК-ийн **Худалдаа хөгжлийн банк 499085408** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.8. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах харилцан тохиролцож шилжүүлнэ.
 - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хоронго болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
 - 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах
 - 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
 - 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
 - 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
 - 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
 - 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
 - 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р багийн нутаг дэвсгэрт орших “ТҮМЭН ЭГШИГ ХХК БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тэвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-г заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тэвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:
ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ ХХК-ийн
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

.....*Пүрэвдорж*..... / Э.Пүрэвдорж /
Суурин утас: 95447077

Гар утас: 88555035

Регистер:2569477

УБ гэрчилгээний дугаар: 9011107057

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:
MV-002425

Хаяг: Дорноговь аймаг, Өргөн сум, 1-р баг,
Сөгдөх уул, Сөгдөхийн шохой
боловсруулах үйлдвэр

Email хаяг: Yalguunlime@gmail.com

Хүлээн авагч талыг төлөөлж:
ТҮМЭН ЭГШИГ ХХК-ийн
ЕРӨНХИЙ МЕНЕЖЭР

ХИМИЙН ХСРТ БОЛОН
АЮУЛТАЙ БОДИСЫН
СЭЛЭГ Б.Одбаяр
ДАХИН БОЛОВСРУУЛАХ
ЭКО ҮЙЛДГЭЭР
Суурин утас: 7711128
ТЕХНИКИЙН АЛБА
Гар утас: 91918828,88990428

Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-0000022

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Намъянжуугийн – 44 ,Түмэн эгшиг ХХК-
ийн ,өөрийн байр

Email хаяг:chemicalwasterisk@gmail.com

Шуудангийн хаяг:51 салбар 499 тоот

“Түмэн эгшиг” ХХК, “Ялгуун интернэшнл” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2024 оны дугаар сарын -ны өдрийн
..... тоот гэрээний Хавсралт № 01

2024-2025 онд ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙ ЖИЛД УСТГУУЛАХ
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1						
2						
3						
4						
5						

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

Үүсгэгч талыг төлөөлж:
ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ ХХК-ийн
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРТЭЖИЛТЭН

.....*Пүрэвдорж*..... / Э.Пүрэвдорж /
Суурин утас: 95447077

Гар утас: 88555035

Регистер: 2569477

УБ гэрчилгээний дугаар: 9011107057

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:
MV-002425

Хаяг: Дорноговь аймаг, Өргөн сум, 1-р баг,
Сөгдөх уул, Сөгдөхийн шохой
боловсруулах үйлдвэр

Email хаяг: Yalgunlime@gmail.com

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ

Хүлээн авагч талыг төлөөлж:
Түмэн эгшиг ХХК-ийн
Ерөнхий Менежэр
.....*В.Олбаяр*.....
Хуульч зөвлөх
.....*Г.Алтанчимэг*.....
ИНЖЕНЕР
Суурин утас: 77110428

Гар утас: 99016997

Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: -000001

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Намъянжугийн – 44, Түмэн эгшиг ХХК-
ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: chemicalwasterisk@gmail.com

Шуудангийн хаяг: 51-салбар 499

Дорноговь аймгийн Өргөн сумын 1-р багт байрлах Хавцгай хэмээх эвдэрсэн газарт дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу техникийн нөхөн сэргээлт хийсэн ажлын акт

2023.06.23


Ялгуун интернэшнл ХХК нь Өргөн сумын ЗДТГазар , Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнтэй харилцан зөвшилцөж замын хайрга бэлтгэж ухаад орхигдсон эвдэрсэн 4403009060 нэгж талбарын дугаартай талбайн эвдрэлд орсон 1,7га газрыг 3 жилийн хугацаанд техникийн нөхөн сэргээлт хийх үүрэг хүлээсэн бөгөөд эхний жил буюу 2023 онд 0.69га /6900м2/ эвдэрсэн талбайд 1150м³ уулын цулыг хөдөлгөж 2023оны 06сарын 21, 22, 23нд нийт 3 өдөр техникийн нөхөн сэргээлт хийж хэвгийжүүлсэн болно. Уг ажилд Ялгуун Интернэшнл ХХК-ний ХАБЭАБО-н хариуцсан мэргэжилтэн П.Батдорж, Өргөн сумын БО-ны бодлогын мэргэжилтэн А.Рэнцэнханд нар хяналт тавин ажиллалаа.

/Ажлын гүйцэтгэлийн явцийг зургаар хавсаргав./


Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газрын байршил

1. 44°41'35.59" N 110°43'15.2"E
2. 44°41'34.74" N 110°43'12.73"E
3. 44°41'35.59" N 110°41'35.59"E
4. 44°41'35.59" N 110°41'35.59"E

Хүлээлгэн өгсөн:
"Ялгуун Интернэшнл ХХК" ний
захирагч  Баярсайхан
ЯЛГУУН ИНТЕРНЭШНЛ ХХК-НИЙ САЛБАР
ТТAS141 2256947
ДОРНОГОВЬ АЙМАГ

Хүлээн авсан:
Өргөн сумын засаг
дарга  Г. Баярболд
Өргөн сумын БО-ны бодлогын
мэргэжилтэн  А.Рэнцэнханд

2023онд дүйцүүлэх арга хэмжээний дагуу техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн Google earth дээрээс харагдах байдал




Дорноговь аймгийн Өргөн сум

Нэгж талбарын дугаар: 4403009060 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 9027394 Хуулийн этгээдийн нэр: Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргын тамгын газар ЗДТГ-ын дарга: О.Цасанцэцэг

ХАЯГ:	Аймаг/Хот: Дорноговь	Сум/Дүүрэг: Өргөн	Баг/Хороо: 1-р баг	Кадастрын муж: 0030
	Гудамж: Тоот:			



Зургийн масштаб = 1:1543 (1 сантиметрт 15.43 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2022-06-15

Орчны тойм

Координатын систем:
WGS84/UTM 49N
EPSG: 32649



Нэгж талбар

Масштаб = 1:13542

№	X	Y	Урт
1	477625.90	4948920.23	118.05
2	477658.08	4948806.88	269.49
3	477911.74	4948898.57	91.74
4	477881.66	4948985.07	263.57

Барилга

№	X	Y	Урт	Дугаар	Талбай
---	---	---	-----	--------	--------

Талбайн хэмжээ: 27888 квадрат метр



Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn

Техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнө





Нөхөн сэргээлт хийж буй ажлын явцын зургууд









Нөхөн сэргээлтийн дараах зурагнууд

